

425



**МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Самбуугийн гудамж 11, Засгийн газрын 11-р байр.  
Утас: 264216, Факс: 264460,  
E-mail: info@csc.gov.mn

2020.12.11 № 01/2104  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлэг хянуулах талаар

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
М.ӨНӨРЖАРГАЛ ТАНАА

*Б.Нямсүрэн*  
Сүнсү, баянхонгор аймаг  
дэргэс карт албан  
өгсгөөр нэвчлэн  
*[Signature]*

Төрийн албаны эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэх талаар идэвх,  
санаачилгатай хамтран ажиллаж байгаа Танд энэ өдрийн мэнд хүргэе.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын  
зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу төрийн албанд  
томилуулахаар нэр дэвшүүлж байгаа иргэний хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлгийг хянуулахаар Авлигатай тэмцэх газарт хүсэлт гаргадаг бөгөөд Төрийн  
албаны тусгай шалгалт буюу тухайн албан тушаалын шалгалт өгч зохих журмын  
дагуу нэр дэвшүүлсэн нэр дэвшигчийн материалыг хүргүүлэх эрх зүйн  
зохицуулалттай.

Гэтэл Авлигатай тэмцэх газарт төрийн албаны тухай хууль, журмыг зөрчин  
төрийн албаны ерөнхий шалгалт өгөөгүй, төрийн жинхэнэ албаны нөөцөд  
бүртгэлгүй, төрийн албаны тусгай шалгалт буюу тухайн албан тушаалын шалгалт  
өгч Зөвлөл болон Салбар зөвлөлөөс нэр дэвшүүлээгүй иргэний хувийн ашиг  
сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянуулахаар төрийн байгууллагуудаас хүсэлт  
хүргүүлж байгаа тухай Төрийн албаны зөвлөлд мэдэгдэж байна.

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх хэсэгт “төрийн  
жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд шатлан  
дэвших зарчмын дагуу төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан  
хаагчдаас эсхүл удирдах албан тушаалтны нөөцөд байгаа иргэдээс”, 27.1.2, 27.1.3  
дахь хэсэгт “төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах түшмэлийн албан  
тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа  
албан хаагчдаас, эсхүл холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа  
төрийн албан хаагчдаас, дээрх албан хаагчдаас нөхөх боломжгүй тохиолдолд  
нөөцөд байгаа иргэдээс төрийн албаны тусгай шалгалт авч нөхнө гэж тус тус  
заасан.

Цаашид төрийн албаны тухай хууль журамд заасан эрх зүйн зохицуулалтыг  
баримтлан төрийн жинхэнэ албаны сул орон тооны сонгон шалгаруулалтад  
оролцож, нэр дэвшүүлсэн, албан тушаалын тодорхойлолтын шаардлага хангасан  
иргэний нэрийг дэвшүүлж хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулж  
байхыг онцгойлон анхааруулъя.

Төрийн албаны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-т “. . . төрийн албаны төв байгууллага энэ хуулийн 22, 23, 26, 27, 28, 31 дүгээр зүйлд заасныг зөрчсөн эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгож, буруутай албан тушаалтныг чөлөөлөх . . .” гэж заасан байгааг анхаарч холбогдох харьяа газрууддаа мэдэгдэж, хяналт тавьж ажиллана уу.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ